

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/21/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 260512 Цахим хаяг: Boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал: Н.Цэрэнханд

Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Албан шаардлага	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

「ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.БАТСАЙХАН
ТАНАА

2024.03.15 № 07/680
танай _____-ныг № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 70.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1, 31 дүгээр зүйлийн 31.3.2, ТБОНӨХБАУХАТХ-ийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 44 дүгээр зүйлийн 44.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7-д заасантай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Гадаад валютын ханшийн хэлбэлзэл, ялангуяа гол экспортлогч улс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын юаны ханш өмнөх онтой харьцуулахад 8.7 хувиар өссөн, өмнөх оны хэрэгжээгүй гэрээний 2,500.0 сая төгрөгийг хүлээн авсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж, зохион байгуулаагүйгээс нийт 182.4 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авалтыг хувь хүн, хуулийн этгээдтэй 14 шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2023 онд 18 аймгийн 70 сумын 86 хоршоотой байнгын бус гишүүний гэрээ байгуулан хамтран ажиллаж, 220 удаагийн арилжаа зохион байгуулж 1662 хэлцлээр хийж, нийт 968.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	949,553,929.32	4,460,352,687.07
1.1.2	Дансны авлага	2,027,583,444.94	2,090,811,939.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	84,569,031.76	-
1.1.4	Бусад авлага	17,542,033.00	17,472,315.50
1.1.6	Бараа материал	7,966,033.58	11,905,674.36
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	73,962,006.00	37,164,156.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,161,176,478.60	6,617,706,772.24
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,998,116,561.12	1,814,874,318.00
1.2.2	Биет бус хөрөнгө	1,509,105,178.69	1,450,665,127.86
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,507,221,739.81	3,265,539,445.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,668,398,218.41	9,883,246,218.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	16,805,177.54
2.1.1.3	Татварын өр	184,298,781.40	553,055,141.09
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр	3,900,000.00	900,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	188,198,781.40	570,760,318.63
2.2	Өр төлбөрийн нийт дүн	188,198,781.40	570,760,318.63
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: -төрийн	1,021,700,000.00	1,021,700,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,000.00	10,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	5,458,489,437.01	8,290,775,899.47
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,480,199,437.01	9,312,485,899.47
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,668,398,218.41	9,883,246,218.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,058,341,750.78	5,604,367,138.10
3	Нийт ашиг (алдагдал)	7,058,341,750.78	5,604,367,138.10
4	Түрээсийн орлого	9,000,000.00	-
5	Хүүгийн орлого	30,406,546.39	31,010,130.62
8	Бусад орлого	83,851,824.74	2500,622,382.00
9	Борлуулалт маркетингийн зардал	156,569,532.73	299,545,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,754,432,686.05	3,903,462,334.33
12	Бусад зардал	120,433,492.53	125,735,599.94
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(18,924,015.93)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,131,240,394.67	3,807,256,716.45
19	Орлогын татварын зардал	115,447,594.56	380,961,411.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,015,792,800.11	3,426,295,304.93
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,015,792,800.11	3,426,295,304.93

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	6,328,146,636.90	7,349,856,636.90
3	Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	6,328,146,636.90	7,349,856,636.90
4	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	1,015,792,800.11	1,015,792,800.11
7	Зарласан ногдол ашиг	-	-	1,885,450,000.00	1,885,450,000.00
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	5,458,489,437.01	6,480,199,437.01
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө адааны залруулга			(86,112,442.47)	(86,112,442.47)
11	Залруулсан үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	5,372,376,994.54	6,480,199,437.01
12	Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	3,426,295,304.93	3,426,295,304.93
15	Зарласан ногдол ашиг	-	-	507,896,400.00	507,896,400.00
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,700,000.00	10,000.00	8,290,775,899.47	9,312,485,899.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	351,067,036,797.68	385,347,865,333.68
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,124,431,074.14	5,418,956,811.18
	Бусад мөнгөн орлого	343,942,605,723.54	379,928,908,522.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	349,870,661,482.99	381,166,343,209.45
	Ажиллагчдад төлсөн	941,786,527.00	1,075,596,937.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	281,579,436.08	358,448,067.08
	Бараа материал худалдан авахад төлсөн	13,451,010.37	14,721,724.52
	Ашиглалтын зардалд төлсөн	191,196,923.27	35,328,705.99
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	21,561,209.09	1,350,000.00
	Татварын байгууллагад төлсөн	479,867,327.98	134,364,353.06
	Бусад мөнгөн зарлага	347,941,219,049.20	379,546,533,421.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	1,196,375,314.69	4,181,522,124.23
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	30,406,546.39	31,010,130.62
	Хүлээн авсан хүүгийн орлого	30,406,546.39	31,010,130.62
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	200,419,580.00	193,837,097.10
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	180,519,580.00	38,837,097.10
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,900,000.00	155,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(170,013,033.61)	(162,826,966.48)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,885,450,000.00	507,896,400.00
	Төлсөн ногдол ашиг	1,885,450,000.00	507,896,400.00

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,885,450,000.00)	(507,896,400.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(859,087,718.92)	3,510,798,757.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,808,641,648.24	949,553,929.32
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	949,553,929.32	4,460,352,687.07

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	а) Арилжааны хэмжээ	тонн	27,172.64	42,551.61	15,378.97	156.6
	Ноолуур	тонн	6,183.31	6,183.31	-	100.0
	Хонины ноос	тонн	9,789.27	9,901.60	112.33	101.1
	Тэмээний ноос	тонн	1,251.93	962.50	(289.43)	76.9
	Ямааны завод ноос	тонн	2,029.23	2,244.50	215.27	110.6
	Хонины завод ноос	тонн	202.23	227.70	25.47	112.6
	Тосны ургамал	тонн	4,716.67	18,632.00	13,915.33	395.0
	Арьс шир	ширхэг	3,000.00	4,400.00	1,400.00	146.7
1	б) Арилжааны дүн	тэрбум.төг	915.80	941.15	25.35	102.8
	Ноолуур	тэрбум.төг	838.19	838.19	0.00	100.0
	Хонины ноос	тэрбум.төг	18.14	16.19	(1.96)	89.2
	Ямааны завод ноос	тэрбум.төг	43.41	47.83	4.42	110.2
	Тэмээний ноос	тэрбум.төг	10.60	7.89	(2.71)	74.5
	Хонины завод ноос	тэрбум.төг	0.25	0.36	0.10	140.4
	Тосны ургамал	тэрбум.төг	5.19	30.67	25.48	591.1
	Арьс шир	тэрбум.төг	0.01	0.01	0.00	137.5
2	Нийт орлого	мян.төг	5,519,918.64	8,135,999.65	2616,081.01	147.4
3	Нийт зардал	мян.төг	4,396,303.90	4,328,742.93	(67,560.97)	98.5
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	1,123,614.74	3,807,256.72	2,683,641.98	338.8
5	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	1,011,253.27	3,426,295.30	2,415,042.04	338.8
6	Нийт төсөвт төлөх татвар:	мян.төг	546,163.27	869,672.82	323,509.54	159.2
	а) Орлогын татвар	мян.төг	112,361.47	380,961.41	268,599.94	339.0
	б) ХХОАТ	мян.төг	121,219.36	130,263.34	9,043.98	107.5
	в) ЭМНДШ	мян.төг	312,582.44	358,448.07	45,865.63	114.7
7	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	36.00	36.00	-	100.0
8	Нийт цалингийн сан	мян.төг	1,398,355.00	1,374,801.68	(23,553.32)	98.3
9	Хөрөнгө оруулалт	мян.төг	166,590.00	163,837.10	(2,752.90)	98.3
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.80	0.77	0.03	66.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь дүрэмдээ “Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, бараа түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд /танхимын болон цахим сүлжээгээр/ зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх” гэж эрхэм зорилгоо тодорхойлон үйл ажиллагаа явуулж иржээ.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо бий болгох, бараа, түүхий эдийн спот болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг эрхлэх, арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд танхимын болон цахим сүлжээгээр зохион байгуулах” гэж тодорхойлжээ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хүрээнд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Авлигын эсрэг хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөдөө Аж Ахуйн Бирж ХХК нь дотоод хяналт, шалгалт хийх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хяналтын журмыг үндэслэн давхардсан тоогоор 11 удаагийн шалгалт хийсэн, хяналтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хэлтэс тус бүрээр дүгнэж 24 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Үүнээс хэрэгжих хугацаа болоогүй 14 зөвлөмж байна. Зөвлөмжийн биелэлт 42.0 хувийн хэрэгжилттэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд боловсруулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,214.8 сая төгрөгөөр буюу 48.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	949,553.93	4,460,352.69	3,510,798.76
Авлага	2,129,694.51	2,108,284.26	(21,410.25)
Бараа материал	7,966.03	11,905.67	3,939.64
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	73,962.01	37,164.16	(36,797.85)
Үндсэн хөрөнгө	3,507,221.74	3,265,539.44	(241,682.30)
Нийт хөрөнгө	6,668,398.22	9,883,246.22	3,214,848.00
Өр төлбөр	188,198.78	570,760.32	382,561.54
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,480,199.44	9,312,485.90	2,832,286.46
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,668,398.22	9,883,246.22	3,214,848.00

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 4,460.4 сая төгрөг болж 3,510.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Компанийн ТУЗ-ийн 2022 оны 18 дугаар тогтоолын дагуу "Хөдөө аж ахуйг дэмжих сан", "Хөдөө аж ахуйн бирж" ХХК нарын хооронд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 23-237 дугаартай "Хамтран ажиллах бодлогын гэрээ"-ний хэрэгжилтийг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр дүгнэж, гэрээний ерөнхий нөхцөлийн 2.1, 5.3-т заасан давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан биелэгдээгүй тул талууд харилцан ойлголцож, энэхүү гэрээний 1.2 дахь заалтыг үндэслэн ХААБ ХХК-д гэрээний төлбөр болох 2,500.00 сая төгрөгийг 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдөр төлсөн, урьд онуудын үүссэн авлагаас 979.8 сая төгрөгийг барагдуулж, хүүгийн 31.0 сая төгрөгийн орлогыг хүлээн авсан;

Авлага дансны үлдэгдэл 2,108.3 сая төгрөг болж 21.4 сая төгрөгөөр буурсан нь тайланд онд авлага 5,791.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 5,689.4 сая төгрөгөөр буурч, найдваргүй авлагын нөөц 123.4 сая төгрөгөөр байгуулсан;

Урьдчилж төлсөн зардал данс 37.2 сая төгрөг болж, 36.8 сая төгрөгөөр буурсан нь 2022 онд үүссэн, дууссан урьдчилж гарсан зардлыг тайлант оны зардалд хуваарилсан;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 3,265.5 сая төгрөг болж 241.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд шинээр 26.5 сая төгрөгийн тавилга эд хогшил, 12.3 сая төгрөгийн компьютер бусад хэрэгсэл, 155.0 сая төгрөгийн биет бус хөрөнгө худалдаж авч, 435.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан;

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 570.8 сая төгрөг болж 382.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дансны өр төлбөр 16.8 сая төгрөг, татварын өр төлбөр 365.8 сая төгрөгөөр нэмэгдсэн;

Эздийн өмч дансны үлдэгдэл 9,312.5 сая төгрөг болж 2,832.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэгдсэн өртгийн албан татварын залруулга 86.1 сая төгрөгөөр хасагдаж, тайлант үеийн үр дүн 3,426.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 507.9 сая төгрөгийн ногдол ашиг шилжүүлсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2023 оны 21 дугаар тогтоолоор “2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,519.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,396.3 сая төгрөгөөр, 1011.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 166.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 8,136.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,328.7 сая төгрөгийн зардал гарган, 3,807.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 8,136.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,616.1 сая төгрөг буюу 47.0 хувиар давсан нь бусад орлого 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдэж, гадаад валютын ханшийн хэлбэлзэл, ялангуяа гол экспортлогч улс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын юанийн ханш өмнөх онтой харьцуулахад 8.7 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 4,328.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 67.6 сая төгрөг хэмнэсэн байна. Энэ нь сургалт судалгаа хөгжүүлэлтийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, нийгмийн хамгаалал хүний нөөцийн үйл ажиллагааны зардлуудыг хэмнэсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 163.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 3,426.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,415.0 сая төгрөгөөр илүү байгаа нь борлуулалтын орлогыг 116.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, бусад орлого 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт зардлыг хэмнэж ажилласан нь нөлөөлжээ.

Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын дансанд өмнөх оны ногдол ашгийн 507.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар анхан шатны, ҮАГ-ын СНАГ-ын ахлах аудитор С.Бат-эрдэнэ, аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц. Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 36 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт орлогын 7,058.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 70.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, шаардлагагүй бараа материал, хангамжийн зүйлсийг худалдан авахгүй байх, шатахууны зардлыг гаргахгүй байх, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшуулал, дэмжлэг олгохгүй байх, ашиглалтын зардал, түрээсийн зардлыг хэмнэх зэрэгт анхаарч 159.8 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2,942.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 8,948.5 сая төгрөгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,102.5 сая төгрөгийн 24 гүйлгээ, зарлагын 1,314.1 сая төгрөгийн 75 гүйлгээ, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийн 243.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 282.9 сая төгрөгийн 26 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Компанийн 2023 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд төсөвт оруулах ногдол ашгийг төлөвлөж, тайлагнаагүй байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана", 5-д "төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг", Компанийн дүрмийн 11.5.5-д "Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу ногдол ашгийн хэмжээ түүнийг төлөх журмыг тодорхойлж хуваарилах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хууль, тогтоомжид Төлөөлөн удирдах зөвлөлөөр компанийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулахдаа төсөвт оруулах ногдол ашгийг төлөвлөж, тайлагнаж байх зөвлөмж өгөв.

2. "Компанийн дүрэм"-ийн 11 дүгээр зүйлийн 11.5-д "ТУЗ нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас бусад дараах бүрэн эрхтэй байна" гэж заасан бүрэн эрхэд төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана", 16.2.5-д "хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох талаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайланд 0.35 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 25.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 76.5 сая төгрөгийн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	350.0	1	350.0	100.0
Албан шаардлага	1	25,354.8	1	25,354.8	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	4	25,704.8	4	25,704.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус биржийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа, клиринг төлбөр тооцоо, итгэмжлэл, гишүүнчлэлийн журмын хэрэгжилтэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,500.0 сая төгрөгийн 1 алдааг¹ залруулав.

Залруулсан алдаа:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 18 дугаар тогтоолын дагуу “Хөдөө аж ахуйг дэмжих сан”, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нарын хооронд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 23-237 тоот “Хамтран ажиллах бодлогын гэрээ”-ний хэрэгжилтийг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр дүгнэж, гэрээний ерөнхий нөхцөлийн 2.1, 5.3-т заасан давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан биелэгдээгүй тул талууд харилцан ойлголцож, энэхүү гэрээний 1.2 дахь заалтыг үндэслэн Хөдөө аж ахуйн бирж ХХК-д гэрээний төлбөр болох 2,500.0 сая төгрөгийг 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдөр төлсөн байна.

Үүнийг өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан ашиг дансны өмчид гарсан өөрчлөлтөөр нэмэгдүүлж тайлагнасан нь төрийн өмчид ногдох ногдол ашиг, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг дутуу тооцоолох үр дагавар үүссэн нь “ангилал” буюу ажил гүйлгээ үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд компанийн тайлант оны санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, зорилтот түвшний тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 209.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 209.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 139.2 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/87 тоот тушаалаар Үндэсний их баяр наадмыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд зохион байгуулахад 27.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-д “өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах”, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ний 2023 оны тодотгосон төсөв, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, ... зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Компанийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж, зохион байгуулаагүйгээс нийт 182.4 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авалтыг хувь хүн, хуулийн этгээдтэй 14 шууд гэрээгээр гүйцэтгэсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Засгийн газрын “Босго үнэ

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шинэчлэн батлах тухай" 2021 оны 124 дүгээр тогтоол "харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаартай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 672.4 сая төгрөгийн 248 нэр төрлийн ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд дахин үнэлгээ хийх, үнийг шинэчлэн тогтоох талаарх саналыг боловсруулж ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 -д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж, шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй, ашиглаж буй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2. Ажил гүйлгээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний орлогын баримтыг урьдчилан дугаарлаагүй, нярвын хүлээж авсан баримтаар нягтлан бодогч ажил гүйлгээг бүртгэсэн, бараа материалын зарлагын шаардах хуудаст гарын үсгийн бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг урьдчилан дугаарлаж, хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэж, тайлагнаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил гүйлгээ үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна	1	2,500,000.0			1	2,500,000.0	1	2,500,000.0				
Дүн	1	2,500,000.0			1	2,500,000.0	1	2,500,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бэлэн мөнгөний орлогын баримтыг урьдчилан дугаарлаагүй, нярвын хүлээж авсан баримтаар нягтлан бодогч ажил гүйлгээг бүртгэсэн, бараа материалын зарлагын шаардах хуудасны гарын үсгийн бүрдэл дутуу байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 672.4 сая төгрөгийн 248 нэр төрлийн ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд дахин үнэлгээ хийх, үнийг шинэчлэн тогтоох талаарх саналыг боловсруулж ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна	1						1	-			-	-
Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/87 тоот тушаалаар Үндэсний их баяр наадмыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд зохион байгуулахад 27.4 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	27,418.0	-	-	1	27,418.0	-	-			-	-

Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж, зохион байгуулаагүйгээс нийт 182.4 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авалтыг "Мэдээлэл нийтлэгч" гэх хувь хүн, хуулийн этгээдтэй 14 удаагийн шууд гэрээгээр гүйцэтгэсэн	1	182,400.0			1	182,400.0						
Дүн	4	209,818.0	-	-	2	209,818.0	2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,102.5 сая төгрөгийн 24 гүйлгээ, зарлагын 1,314.1 сая төгрөгийн 75 гүйлгээ, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийн 243.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 282.9 сая төгрөгийн 26 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.	1	2,942,667.00	1	2,942,667.00	-	-
Дүн	1	2,942,667.00	1	2,942,667.00		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Компанийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд төсөвт оруулах ногдол ашгийг төлөвлөж, тайлагнаагүй байна.	1	-	-	-	1	-
"Компанийн дүрэм"-ийн 11 дүгээр зүйлийн 11.5 -д "ТУЗ нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас бусад дараах бүрэн эрхтэй байна" гэж заасан бүрэн эрхэд төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтгүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	2				2	-
Нийт дүн	3	2,942,667.00	1	2,942,667.00	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 433/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2024/21/НА-ЦА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,102,195,095.00 /нэг тэрбум нэг зуун хоёр сая нэг зуун ерөн таван мянга ерөн таван/ төгрөгийн 24 гүйлгээ, зарлагын 1,314,075,387.00 /нэг тэрбум гурван зуун арван дөрвөн сая далан таван мянга гурван зуун наян долоон/ төгрөгийн 75 гүйлгээ, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийн 243,500,000.00 /хоёр зуун дөчин гурван сая таван зуун мянган/ төгрөгийн 3 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 282,896,521.00 /хоёр зуун наян хоёр сая найман зуун ерөн зургаан мянга таван зуун хорин нэгэн/ төгрөгийн 26 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.3-д "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосгоо-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SNAГ-2.Docx

0001000973



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 431/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2024/21/НА-СТА-70А

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:




Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж, зохион байгуулаагүйгээс нийт 182,400,000.00/ нэг зуун наян хоёр сая дөрвөн зуун /мянган төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авалтыг хувь хүн, хуулийн этгээдтэй 14 удаагийн шууд гэрээгээр гүйцэтгэсэн.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2021 оны 124 дүгээр тогтоол " шууд худалдан авч болох төсөвт төсөвт өртгийн дээд хязгаар"20,000,000.00 /Хорин сая/ төгрөг гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д " төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль, тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, бараа, ажил, үйлчилгээний төсөв өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын зохих аргыг хэрэглээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТЫН МЕНЕЖЕР  Ч.БОЛД
 ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  Н.ЦЭРЭНХАНД



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SNAG-7.Docx

0001080971



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 432/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2024/2111А-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/87 тоот тушаалаар Үндэсний их баяр наадмыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд зохион байгуулахад 27,418,000.00 /хорин долоон сая дөрвөн зуун арван найман мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ний 2023 оны тодотгосон төсөв, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, ... зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Компанийн хөрөнгийг үндсэн чиг үүргийн дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн бирж ХХК-ний гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, ерөнхий нягтлан бодогч /Б.Номин-Эрдэнэ/нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA9623 9006109
000000533

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SNAG-2.Docx

0001093975